

ХАЯГИЙН ШИЛЖҮҮЛЭГ ХИЙЛГЭЭГҮЙ ОРШИН СУУГЧДЫН 20... ОНЫ БҮРТГЭЛ

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Дүүргийн нэр:

Хорооны дугаар:

код	

1. Хорооны Засаг дарга жил бүрийн 2-р сарын 20-ны дотор дүүргийн ЗДТГ-т цахим хэлбэрээр хүргүүлнэ.
2. Дүүргийн ЗДТГ нь 2-р сарын 25-ны дотор НЗДТГ-ын НЗУХ-т цахим хэлбэрээр хүргүүлнэ.
3. НЗДТГ-ын НЗУХ нь 2-р сарын 28-нд ҮСХ-нд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2. БҮРТГЭЛИЙН ХЭСЭГ

Д/д	Оршин сууж буй хаягтаа бүртгэлгүй иргэний		Регистрийн дугаар	Хүйс: эрэгтэй-1 эмэгтэй-2	Албан ёсны бүртгэлтэй хаяг				Оршин сууж буй гудамж, тоот	Одоогийн хаягтаа суурьшиж буй Хугацаа: 6 сар хүртэл - 1, 6 сараас дээш - 2	Хорооны Засаг даргаас авсан арга хэмжээ	Шийдвэрлэгдсэн байдал, код тавих
	Овог	Нэр			Аймаг, нийслэлийн код	Сум, дүүргийн код	Баг, хорооны код	Гудамж, тоот				
А	1	2	3	4	5а	5б	5в	5г	6	7	8	9

Шаардлагатай тохиолдолд ЭАБ-19 маягтын дагуу нэмэлт хуудсаар мэдээллийг цуглуулна.

Бүртгэсэн: Албан тушаал: _____ Гарын үсэг: _____ \

Хянасан: Албан тушаал: _____ Гарын үсэг: _____ \

Тамга\тэмдэг

Хаягийн шилжүүлэг хийлгээгүй оршин суугчдын бүртгэлийн маягт (ЭАБ-19)-ыг нөхөх заавар

Энэ судалгааг хорооны Засаг дарга маягтын дагуу гаргаж дүүргийн ЗДТГ-т тогтоосон хугацаанд цахим хэлбэрээр хүргүүлнэ. Дүүргийн ЗДТГ нь судалгааг хороо бүрээр нэгтгэж, цахим хэлбэрээр НЗДТГ-т, НЗДТГазар мэдээллийг хороо, дүүргээр нэгтгэн, тогтоосон хугацаанд Үндэсний статистикийн хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- 01, Багахангай дүүрэг- 04, Баянгол дүүрэг- 07, Баянзүрх дүүрэг- 10, Налайх дүүрэг- 13, Сонгинохайрхан дүүрэг- 16, Сүхбаатар дүүрэг- 19, Хан-Уул дүүрэг- 22, Чингэлтэй дүүрэг- 25 гэсэн кодыг зохих нүдэнд бөглөнө. Хорооны дугаарыг бичиж, кодыг "Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр"-ийг нөхөх заавар болон "Хүн ам" мэдээллийн санг байгуулах заавраас харж нөхнө. Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (утас 328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон ubstat.mn цахим хуудсаас энэ кодыг мэдэх боломжтой.

2. БҮРТГЭЛИЙН ХЭСЭГ

Нийслэл хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгж болох хороонд 183-аас дээш хоногоор албан ёсоор бүртгүүлээгүй оршин суугчийг хаягийн бүртгэлгүй оршин суугч гэнэ. Өөрөөр хэлбэл хорооны "Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр"-т бүртгэгдээгүй өрх, оршин суугч юм.

Өрхийн бүх гишүүн тухайн хороонд бүртгүүлэлгүй оршин сууж буй тохиолдолд хаягийн бүртгэлгүй оршин суугч өрхийн тэргүүлэгчээс эхлэн бүх хүнийг бүртгэнэ. Харин тухайн хороонд бүртгэлтэй өрхөд хаягийн бүртгэлгүй оршин суугч амьдарч байгаа тохиолдолд зөвхөн хаягийн бүртгэлгүй оршин суугчийн мэдээллийг бүртгэнэ.

1, 2-р баганад хаягийн шилжүүлэг хийлгээгүй оршин суугчдын овог, нэрийг түүний иргэний цахим үнэмлэх болон бусад нотлох бичиг баримтыг үндэслэн нөхнө.

3-р баганад хаягийн шилжүүлэг хийлгээгүй оршин суугчдын регистрийн дугаарыг иргэний цахим үнэмлэх болон бусад нотлох бичиг баримтыг үндэслэн нөхнө.

4-р баганад хүйсийг эрэгтэй (1), эмэгтэй (2) гэсэн кодын аль нэгийг нөхнө.

5-р баганад хаягийн шилжүүлэг хийлгээгүй оршин суугчдын албан ёсны бүртгэлтэй байгаа хаягийг иргэний цахим үнэмлэхнээс харж, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны нэрийг товч бичин, засаг захиргааны нэгжийн кодыг доод талд нь нөхнө. Хэрвээ 16 нас хүрээгүй хүүхэд байвал албан ёсны бүртгэлтэй хаягийг эцэг, эхийн иргэний цахим үнэмлэхийн хаягтай ижил нөхнө.

6-р баганад хаягийн шилжүүлэг хийлгээгүй оршин суугчдын одоогийн амьдарч байгаа хэсэг, гудамж, тоотыг бичнэ.

7-р баганад хаягийн шилжүүлэг хийлгээгүй оршин суугчдын тухайн хороонд хаягийн бүртгэлгүйгээр оршин сууж эхэлсэн хугацааг нөхөхдөө 6 сар хүрлэх хугацаанд амьдарч байгаа бол 1, 6 ба түүнээс дээш сараар амьдарч байгаа бол 2 гэсэн код нөхнө.

8-р баганад хаягийн шилжүүлэг хийлгээгүй оршин суугчдад "Иргэний бүртгэлийн тухай" Монгол улсын хууль, Монгол Улсын нутаг дэвсгэрт шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмын дагуу хорооны Засаг даргаас хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ.

9-р баганад хаягийн шилжүүлэг хийлгээгүй оршин суугчдын хаягийн бүртгэл хэрхэн шийдвэрлэгдсэн байдлыг тохирох кодоор нөхнө. Үүнд:

Тухайн хороонд албан ёсны бүртгэлтэй болсон - 1,

Өөр аймаг, дүүрэг, сум, хороонд шилжин суурьшсан - 2,

Хаягийн бүртгэлгүй оршин суусан хэвээр байгаа - 3